



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИСС

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж 13, 15140-0036
Утас/Факс: (976-11) 31-83-92
E-mail: nok.ulaanbaatar@gmail.com
<http://www.nobg.ub.gov.mn>

2021. 11. 16 № 717

танай _____-ны № _____-т

Дархлаажуулалтыг идэвхжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 118, 259 дүгээр тогтоолын дагуу Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг, халдварын тархалтын “Улбар шар” түвшинд Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтыг бууруулах, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, хариу арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Цаашид нийгэм, эдийн засаг, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа, иргэдийн орлогыг тасалдуулж хөл хорио тогтоохгүй байх бодлого баримталж байгаа бөгөөд дархлаа сэргээх нэмэлт тунд хүн амын 50%-ыг хамруулан халдварын тархалтын “Улбар шар” түвшнээс “Шар”, “Ногоон” түвшинд шилжин ердийн горимд ажиллах талаар уриалга гаргасан.

Нийслэлийн хэмжээнд Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаажуулалтыг 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс эхлүүлж, өнөөдрийн байдлаар дархлаа сэргээх нэмэлт тунд 262,284 хүн буюу нийт хүн амын 17.8%, зорилтот бүлгийн 24.8% хамрагдаад байна.

Иймд дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу дархлаа сэргээх нэмэлт тунд төрийн албан хаагчдын манлайлал, оролцоог нэмэгдүүлж, ажилтан, албан хаагчдаа дархлаажуулалтад идэвхтэй хамруулж ажиллана уу.

ДАРГА



Д.СУМЪЯАБАЗАР